



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 12 сарын 19 өдөр

Дугаар А/668

Хэрлэн сум

**Бор-Өндөр сумын хүүхдийн 4 дүгээр
цэцэрлэгийг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг 7.6 дахь хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бор-Өндөр суманд 200 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилга шинээр ашиглалтад орж, Боловсролын газрын дүгнэлт гарсан тул Бор-Өндөр сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийг байгуулсугай.

2. Шинээр байгуулсан цэцэрлэгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу мэргэжлийн удирдлага зохион байгуулалт, арга зүйн зөвлөгөөгөөр ханган ажиллахыг Боловсролын газрын дарга (С.Мөнхцэцэг)-д, дэмжлэг үзүүлж ажиллахыг Бор-Өндөр сумын Засаг дарга (Г.Адъяабилэгт)-д тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Зоригтбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ